



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 2/108

Улаанбаатар хот

Г Сургалт, дадлага зохион байгуулах тухай Г

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол дүүргийн 70, Сүхбаатар дүүргийн 29, 116 дугаар Тусгай дунд сургуулийн багш, ажилчид, сурагчид, тэдний эцэг эхчүүдэд аюулт үзэгдэл, осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, дадлагыг 2019 оны 10 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалт, дадлагын удирдамжийг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, дадлага зохион байгуулахад шаардагдах 2.775.000 (хоёр сая долоон зуун далан таван мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалтын бэлтгэлийг хангаж, хугацаанд нь зохион байгуулахыг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт, сургалтын явцад хяналт тавьж ажиллахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн
11/108 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ТУСГАЙ ДУНД СУРГУУЛИУДЫН БАГШ, СУРАГЧИД, ТЭДНИЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД
ГАМШИГ ОСОЛ, ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАДЛАГА СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Сургалтын зорилго.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлын хүрээнд нийслэлийн Тусгай дунд сургуулийн багш, ажилчид, сурагчид, тэдний эцэг эхчүүдэд болзошгүй аюулт үзэгдэл, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюул, осол тохиолдсон үед өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг олгоход оршино.

Хоёр. Сургалт дадлага зохион байгуулах бүрэлдэхүүн.

Дадлага сургалтыг нийслэлийн Баянгол, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн орлогч Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, Гал түймэр унтраах, аврах ангиуд хамтран зохион байгуулна.

Гурав. Сургалт дадлагын хамрах хүрээ.

д/д	Дүүрэг	Сургалтанд хамруулах			
		Багш ажилчид	Сурагч хүүхдүүд	Эцэг эхчүүд	Нийт
1	Баянгол дүүргийн 70-р сургууль	30	100	50	180
2	Сүхбаатар дүүргийн 29 дүгээр сургууль	30	100	50	180
3	Сүхбаатар дүүргийн 116 дугаар сургууль	20	50	20	90
Нийт		80	250	120	450

Дөрөв. Сургалт дадлага зохион байгуулах газар, хугацаа

Сургалт дадлагыг 2019 оны 10 дугаар сарын 07-ноос 10-ны өдрүүдэд Баянгол дүүргийн 70, Сүхбаатар дүүргийн 29, 116 дугаар Тусгай дунд сургуулиудын хичээлийн байранд зохион байгуулна.

Тав. Сургалт дадлагын хөтөлбөр

д/д	Сэдэв	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Сургалт, дадлагын нээлт, зорилго, хөтөлбөрийг танилцуулах	10 минут	Тухайн удирдлага, орлогч сургуулийн ОБХ-ийн
2	“Бэлэн бай” сургалтын багцын “Гал түймэр”, Газар хөдлөлт” сэдвийн видео хичээл үзүүлэх	15 минут	ОБХ-ийн урьдчилан асуудал мэргэжилтэн Сургалт, сэргийлэх хариуцсан
2	“Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр сургалт явуулах	60 минут	ОБХ-ийн урьдчилан асуудал мэргэжилтэн Сургалт, сэргийлэх хариуцсан
4	Бэртэж гэмтсэн, түлэгдсэн хүнд анхны тусламж үзүүлэх аргыг заах	15 минут	Дүүргийн загалмайн сургагч багш Улаан хорооны
5	Гамшгийн аюулын дохиогоор объектоос түр цугларах аюулгүй цэгт гарах дадлага хийлгэх	10 мин	ОБХ-ийн орлогч, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн нар
6	Гал унтраах үзүүлэх сургууль хийж үзүүлэх	10 мин	Гал түймэр унтраах аврах ангийн алба хаагчид
Нийт		120 минут	

Зургаа. Тайлан мэдээ ирүүлэх

Сургалтын илтгэх хуудсыг файлаар 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр nobg.surgalt@gmail.com хаягаар, баталгаажуулсан хувийг хамрагдсан хүмүүсийн нэрсийн жагсаалтын хамт 10 дугаар сарын 07-ны өдөр тус тус Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэст ирүүлнэ.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн
А/108 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



СУРГАЛТ, ДАДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт /төгрөг/
а.Цайны материал:					
1	Ундаа	ш	1500	250	375.000
2	Печень, чихэр	ш	1500	250	375.000
3	Кофе	ш	300	500	150.000
4	Нэг удаагийн аяга	ш	150	500	75.000
Хэсгийн дүн					975.000
б.Бичиг хэргийн зардал:					
5	Дэвтэр	ш	3100	200	620.000
6	Бал	ш	900	200	180.000
Хэсгийн дүн					800.000
в.Урамшууллын зүйл:					
7	Сүү	ш	2500	200	500.000
8	Салфетка	ш	2500	200	500.000
Хэсгийн дүн					1.000.000
Нийт					2.775.000